



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/165

Бат-Өлзий сум

Газар эзэмших эрхийг хүчингүй болгох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт “Цэгээн хангайн зам” хязгаарлагдмал хариуцлагатай компанид олгосон авто машины грашийн зориулалттай 0,05 га газар, иргэн Ж.Нямтогтоход олгосон худалдаа үйлчилгээний зориулалттай 0,05 га, “ЭМ СИ И” хязгаарлагдмал хариуцлагатай компанид олгосон орон сууцны зориулалттай 0,15 га газар, Засаг даргын Тамгын газарт олгосон эрчим хүчээр хангах зориулалтаар олгосон 0,068 га газрууд нь газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтыг тус тус зөрчсөн тул газар эзэмших эрхийг хүчингүй болгосугай.

2. Газар эзэмших эрх, эрхийн гэрчилгээг нь хүчингүй болгосон талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мэдэгдэж, холбогдох гэрээ, гэрчилгээг хууль журмын дагуу цуцлахыг Газрын даамал (И.Маралмаа)-д даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын “Газар эзэмшүүлэх тухай” 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/35, 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/145, 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/144, 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/123 дугаар захирамжуудыг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН